



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 9 сарын 12 өдөр

Дугаар 295

Улаанбаатар хот

Г Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх  
тусгай зөвшөөрлийг сэргээх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Нарны хөтөч ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2018 оны 9 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн сэргээсүгэй.
2. Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэхдээ дахин зөрчил дутагдал гаргасан тохиолдолд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болохыг анхааруулж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Нарны хөтөч ББСБ” ХХК /Ц.Болортuya/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийт болон харьялагдах татварын алба, Улсын бүртгэлийн ерөнхий газарт ажлын 10 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА

С.ДАВААСҮРЭН

